



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 152

Улаанбаатар хот

┌ Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх ┐ тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.4, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.3, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн арван наймдугаар хавсралт “Тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт”-ын 2.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хавсралтад дурдсан нэр бүхий 2 иргэнд “Тэнгэр даатгал” ХХК-ийн даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.
2. Тусгай зөвшөөрөл олгосон иргэдэд “Тэнгэр даатгал” ХХК-аас бусад даатгалын компанид даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэхгүй болохыг анхааруулсугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

151800000326

Санхүүгийн зохицуулах хорооны
2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн
152 дугаар тогтоолын хавсралт



“Тэнгэр даатгал” ХХК-ийн даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрөл олгох иргэдийн товч мэдээлэл

№	Овог	Нэр	Регистрийн дугаар	Үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэр	Хаяг, утасны дугаар	Тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхлэх даатгалын хэлбэр
1	Баяраа	Энхцэцэг		Улаанбаатар хот		Автотээврийн хэрэгслийн, Ачааны даатгал, Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын, Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал
2	Батзаяа	Энхшүр		Өмнөговь аймаг		Гэнэтийн осол, эмчилгээний даатгал, Хөрөнгийн даатгал, Автотээврийн хэрэгслийн, Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын, Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал